



**ТӨВ АЙМГИЙН
СҮМБЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 12

Жавхлант

Сум хөгжүүлэх сан"-гийн орон
тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн байгуулах тухай

Сумын Засаг дарга Д.Батбилэгийн өргөн мэдүүлсэн Сум хөгжүүлэх сангийн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай саналыг хэлэлцээд Монгол улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам-ын" 3.3.2, 3.3.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчээс ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Сангийн зөвлөлийн дарга бөгөөд сумын Засаг дарга /Д.Батбилэг/-т даалгасугай.

2.1. Сангийн хөрөнгөөр зээл олгохдоо сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн дагуу жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох зорилтод нийцүүлэн төслийг санхүүжүүлэх.

2.2. Журмын хэрэгжилтийг хангуулж, төсөл сонгон шалгаруулахдаа иргэдийн оролцоог хангах арга хэмжээг зохион байгуулж, мэдээллийг иргэдэд ил тод нээлттэй хүргэж ажиллах.

2.3. Сангийн орлого, зарлагыг хөтлөх үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг мөрдүүлж, сангийн болон үйл ажиллагааны тайлан, үр дүнг бүтэн жилээр Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллах.


3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Г.Амарбаясгалан/-д үүрэг болгосугай.

4. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн 04 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 27 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  АБААСАНХҮҮ



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 06 -ны
өдрийн 12 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



“Сум хөгжүүлэх сан”-гийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт,
тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл

1. Б.Уранчимэг / Сумын ИТХ-ын тэргүүлэгч /
2. Д.Энхтуяа / Төрийн сангийн мэргэжилтэн /
3. Б.Мөнхчулуун / Иргэний төлөөлөл /
4. Д.Эрдэнэтуяа / Иргэний төлөөлөл /
5. Д.Сарантуяа / Баялаг бүтээгч иргэн /

— оОо —

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 06 -ны
өдрийн 12 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



“Сум хөгжүүлэх сан”-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах, чиг
үүрэг бүхий орон тооны бус зөвлөл

1. Д.Батбилэг / Сумын засаг дарга /
2. Б.Эрдэнэчимэг / Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн /
3. О.Ганцэцэг / Банкны төлөөлөл /
4. Ч.Цэдэнбал / Сүмбэр 1-р багийн Засаг дарга /
5. Ш.Цэдэндамба / Баялаг бүтээгч иргэн /
6. Б.Дашдорж / Жавхлант 2-р багийн Засаг дарга /
7. Э.Өлзийгэрэл /Иргэний төлөөлөл /

_____оОо_____